

ТАНИЛЦУУЛГА

“Хүнсний ногооны тариалалт, усалгаатай газар тариаланг дэмжих төсөл”-ийн тухай

ТӨСЛИЙН ЗОРИЛГО, АГУУЛГА:

Энэхүү төслийн зорилго нь одоогийн байгаа услалтын системийг шинэчлэн сайжруулах бөгөөд юуны өмнө сонгож авсан усалгаатай газар тариалангийн урсцыг нэмэгдүүлэх усны менежментийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино. Тухайлбал хүнсний ногооны ургац, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх замаар импортыг бууруулж дотоодын хэрэгцээг хангах явдал юм. 2018 оны байдлаар хүнсний ногооны дотоодын хэрэгцээний 54 хувийг үйлдвэрлэсэн боловч хүн амын өсөлт болон усалгаа болон газар тариалангийн техник технологид оруулах хөрөнгө оруулалтыг нэмэхгүй бол энэ хувь буурах магадлалтай.

Монгол улс усалгаатай газар тариаланг хөгжүүлэх түүхэн хөгжлийн явцад 1980-д оны сүүл хүртэл зөвлөлтийн тусламжаар барьж байгуулсан услалтын системүүдийг нэлээд сайн ажиллуулж байсан туршлагатай. Социалист систем задарч, ардчиллын эхэн үед засгийн газар сангийн аж ахуйн услалтын системийн хувиараа тариалан эрхлэгчид болон хувийн аж ахуйдад шилжүүлсэн байна. Харамсалтай нь хувьчилж авсан хувийн аж ахуйд өөрийн гэсэн сайн менежмент бий болгож чадаагүй. Шилжилтийн үед аж ахуйд ашиг багатай усалгаатай газар тариаланг эрхлэхээс илүү хурдан ашиг олохын тулд услалтын системийн тоног төхөөрөмжийг зарж үрсэн. Үүний үр дүнд услалтын систем үгүй болж усалгаатай газар тариалан уналтад орсон.

Төслийн хүрээнд Монгол улсын Засгийн газар төрийн өмчид буцаан авсан услалтын системээс сонгон шинэчлэн сайжруулж газар тариалан эрхлэх сонирхолтой тариаланчид, аж ахуйн нэгжтэй хамтран газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжлийг дэмжихийг зорьж байна. Хэдийгээр эн тэргүүний зорилго нь үндэсний болон бүсийн хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боловч улмаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжиж малын тэжээлийн импортыг бууруулах зорилгоор үр тариа, малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд анхаарна.

УСЛАЛТЫН СИСТЕМҮҮДИЙГ СОНГОЖ АВСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

АХБ-аас сонгон шалагуулсан “Landll milss” Co.ltd зөвлөх үйлчилгээний баг нь 380-аад услалтын системийн жагсаалтаас 48-ыг сонгон орон нутагт нь хийсэн судалгааны дүнд даархи шалгуур үзүүлэлтийн дагуу 12 услалтын системийг сонгосон.

(i) Ил тод, шударга газар олголтын системийн хүрээнд жижиг ногоочид усалгаатай тариалангийн газрыг ашиглах эрхтэй байх;

(ii) услалтын системийн дэд бүтэц байрлах газар төрийн өмчид байж нүүлгэн шилжүүлэлт хийх асуудал үүсгэхгүй байх (Зөвхөн С ангилал);

(iii) Хэмжээ болон чанарын хувьд шаардлага хангасан найдвартай усны эх үүсвэртэй байх;

(iv) Төслийн хөрөнгө оруулалт нь хамгийн багадаа 9%-ийн эдийн засгийн өгөөжтэй байхуйц зах зээлийн хүртээмжийг хангасан байх;

(v) Байгаль орчинд үзүүлэх томоохон эсвэл хэвийн хэмжээнд оруулах боломжгүй сөрөг нөлөөлөл байхгүй байж (зөвхөн В болон С ангилал) усны нөөцийн тогтвортой ашиглалтыг хангасан байх зэрэг болно.

Төслийн санхүүжилт (сая ам.доллар)

| Эх үүсвэр | Хэмжээ | Эзлэх хувь |
|-------------------------------|-------------|--------------|
| Азийн хөгжлийн банк | | |
| Хөнгөлөлттэй энгийн эх үүсвэр | 25.3 | 92.0 |
| Энгийн эх үүсвэр | 14.7 | |
| Ядуурлыг бууруулах Японы сан | 2.0 | 4.6 |
| Монгол Улсын Засгийн газар* | 1.5 | 3.4 |
| НИЙТ | 43.5 | 100.0 |

*Гааль, татвараас чөлөөлөх хэлбэрээр санхүүжүүлнэ.

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН:

- 17 услалтын системийг шинэчлэн сайжруулснаар 7,9 мянган га талбайг услах нөхцөл бүрдэнэ.

- Гол, хуваарилах болон түр суваг, далд хоолой болон илүүдэл ус зайлуулах байгууламжийг шинэчлэн сайжруулж, 240 га талбайг услах усны хэмнэлттэй, үр ашигтай төвийн эргэлттэй бороожуулагч, дуслын усалгааны төхөөрөмжийг ашиглах боломжийг бүрдүүлнэ.

- Услалтын системийн дэд бүтцийн засвар үйлчилгээ хийх чадавхийг бэхжүүлсэн байна.

- Барилгын ажлын үед нийт 240 ажлын байр бий болгож, ажлын байрны 40 хувь нь эмэгтэйчүүд, 10 хувь нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байна.

- 4000 хүртэл сорьцонд шинжилгээ хийх чадавхи бий болж, агрохимийн аюултай үлдэгдэл бүхий хүнсний хэрэглээ буурч, хэрэглэгчдийн дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд итгэх итгэл нэмэгдэнэ.

- Үр үйлдвэрлэлийн чадавхи хүнсний ногооных 0.65 тн, төмснийх 10 тн-д хүрнэ.

- Мэргэжлийн институци, удирдлагын чадавхи бэхжүүлсэн байна.

- Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх төвөөр дамжуулан Увс, Дорнод, Дархан-Уул аймгийн УГТЭҮХ, УБ хот УХХ зэрэг орон нутгийн 4 судалгааны хүрээлэнгийн услалтын системүүдийг шинэчлэн, сайжруулж, (i) температурын хяналттай ургуулах, бойжуулах тасалгаанууд, хадгалах сэрүүн өрөө, нар, салхины хаалт, хашаа, механикжуулалтын багц, үр цэвэрлэх болон савлах тоног төхөөрөмж, тариалангийн болон сургалтын тоноглол, тоног төхөөрөмж, байгууламжаар хангах; (ii) бага оврын усалгааны системийг сайжруулах (iii) нүүрстөрөгч бага, ургалтын хугацаа урт, хүнсний ногоо болон сайн чанарын үр тариалах хүлэмжийг барьж ашиглалтанд оруулна.

Төслийн хүрээнд хийгдэх услалтын систем

| № | Аймаг | Сум | Услалтын систем нэр талбайн хэмжээ |
|----|------------|-------------|------------------------------------|
| 1 | Говь-Алтай | Жаргалан | Цахир, 206 га |
| 2 | | Халиун | Ёлтон, 320 га |
| 3 | Ховд | Эрдэнэбүрэн | Эрдэнэбүрэн, 2000 га |
| 4 | | Алтай | Боомын ам, 300 га |
| 5 | Баян-Өлгий | Баяннуур | Цул улаан, 161 га |
| 6 | | Сагсай | Улаандэл, 400 га |
| 7 | Завхан | Тэлмэн | Хүрэн тал, 500 га |
| 8 | | Улиастай | Ногоон хашаа, 64га |
| 9 | Сэлэнгэ | Сант | Ивэн гол, 240 га |
| 10 | | Зүүнбүрэн | Охидын тал, 2670 га |
| 11 | Төв | Батсүмбэр | Сөгнөгөр, 140 га |
| 12 | Хэнтий | Хэрлэн | Дулааны тал, 700 га |